

БАТЛАВ. БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ
ОРЧИН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРЛАГЫН ГАЗРЫН ДАРГА:
_____ /А.ЭНХБАТ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ
ХҮЛЭЭСЭН:

“ХУУЧИН АНДУУД” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

_____ /А.ЭЛБЭГСАЙХАН/



**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ
ОРШИХ “ХӨӨТ-3” НҮҮРСНИЙ ИЛ УУРХАЙН 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: МВ-020899/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: 2668505/

Хянасан: БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын шинжээч _____ /

Боловсруулсан:

“Хуучин андууд” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн  Ч.Дэлгэржаргал/

2022 он

АГУУЛГА

1.Төслийн товч танилцуулга	2
1.1 Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгуулга:.....	2
1.2 Төслийн байршил.....	2
1.3 Төслийн хүчин чадал	2
1.4 Уурхайн ашиглалтын технологи	3
1.5 Ажиллах хүч	3
1.6 Цахилгаан хангамж	3
1.7 Усан хангамж	3
2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	4
2.1 Байгаль орчин	4
2.2 Дэд бүтэц	5
3. Байгаль орчинд үзүүлж болзошгүй го ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	6
3.1 Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл.....	6
3.2 Хөрсөнд учруулах нөлөөлөл	6
3.3 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл.....	7
4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	7
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	15
7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	16
9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	16
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	24
14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	26
15. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.....	27
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас ..	Error! Bookmark not defined.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгуулга:

“Хуучин Андууд” ХХК

-Улсын бүртгэлийн дугаар /9011044118/

-Регистрийн дугаар /2668505/

1.2 Төслийн байршил

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Энгэр ус /2-р багийн нутаг дэвсгэрт/



1.3 Төслийн хүчин чадал

“Хуучин Андууд” ХХК нь MV-020899 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Хөөт-3 нүүрсний ордыг ил аргаар 5 жилийн хугацаанд олборлохоор төлөвлөсөн.

Хөөт-3 нүүрсний ил уурхайн жилийн хүчин чадлыг жилд 300мян.тн нүүрс олборлож, борлуулахаар тусгасан.

Тус хугацаанд нийт 13 сая.тн нүүрс олборлох бөгөөд хөрс хуулалтын коэффициент 2.46 м³/тн , хөрсний нийт хэмжээ 3.3 сая.м³ байхаар тооцоо гарсан.

1.4 Уурхайн ашиглалтын технологи

Налуу уналтай, давхарга хэлбэрийн биет бүхий ордын уул техникийн нөхцлөөр ил уурхайд тээвэртэй ашиглалтын систем хэрэглэнэ. Бусад бүх ашиглалтын технологи тохиромжгүй болох нь ордын оршиц, тогтоцын нөхцөл, чулуулгийн шинж чанар, үүсэл ил уурхайн үндсэн хэмжээсүүдээр нотлогдож байна.

1.5 Ажиллах хүч

Хөөтийн нүүрсний ил уурхайд нийт 80 хүн ажлын байраар хангагдана. Одоогоор Баянжаргалан сумаас 4 иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

1.6 Цахилгаан хангамж

Төслийн цахилгаан хангамжийн хувьд “Монгол алт” ХХК-ийн нүүрсний уурхайгаас салбарлуулан 1км урттай 15В-ын өндөр хүчдэлийн ЦДАШ татаж, дэд станцын хаалттай хуваарилах байгууламжаас 0.6 кВ-ын өндөр хүчдэлийн ЦДАШ-аар тэжээгдэнэ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа явуулахаар тооцсон.

Хөөт-3 уурхайн цахилгаан гол хэрэглэгчид нь уурхайн хотхон, ажилчдын байр , ажлын контор, засварын цех, шатахуун түгээх станц зэрэг хэрэглэгчид байна.

1.7 Усан хангамж

Хөөт-3 нүүрсний ордын хэмжээнд илэрсэн газрын доорхи усны найрлагаас шалтгаалан ажилчдын унд, ахуйн усны хэрэглээг Баянжаргалан сумын Цаг уурын станцын урд талд байрлах 2014 онд өрөмдөж тоногдосон 2л/сек ундаргатай нийтийн худгаас хангана.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Байгаль орчин

Уурхай орчмын уур амьсгал нь манай орны хуурай уур амьсгалтай, эх газрын эрс тэс уур амьсгалын шинж хоног, улирлаар тод илэрч байдаг. Тус төслийн хувьд хэрэгжих орчин нь цөлөрхөг хээрийн бүсийн гандуу дулаан уур амьсгалтай, хур тунадас бага, агаарын болон хөрсний температур сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай, тухайн орчны агаарын хуурайшилт эрчимжиж байна.

Хөрс: Баянжаргалан сумын нутаг Монгол орны физик газарзүйн мужлалаар Монголын дорнод талын их мужын дэд муж болох Халхын дундад ба Дарьгангын талархаг мужын ухаа гүвээт талд хамрагдана. Байгалийн бүсчлэлээр хээрийн бүсэд, хөрс-ургамлын бүсчлэлээр хуурай хээрийн хүрэн хөрсний бүсэд багтана. Хөрсний өнгөн гадарга эвдрэлд ороогүй, хэвийн. Хөрс газарзүйн мужлалаар тал хөндий ухаа гүвээ толгод бүхий хуурай хээрийн хүрэн хөрсний бүс. Хөрсний хээрийн судалгаагаар нэг хэв шинжийн 2 хөрс илэрсэн.

Ургамалжилт: Тус лицензийн талбайн 65 га талбай нь нийтдээ сийрэг, тачир ургамалтай, хээрийн судалгааны явцад 2 удаа ургамлын бичиглэл хийсэн. Ашиглалтын лицензтэй талбайн нам толгодын хажуу бэлээр буюу олборлолт явуулж байсан газрын ойролцоо хийсэн бичиглэлээр ургамлан нөмрөгөөр маш ядуу, цөөн тооны бударгана, шаваг ургаснаас өөр ургамалгүй, бусап хэсгээр Ахар навчит баглуур (*Anabasisbrevifolia*), Говийн хялгана (*Spitagobica*), Таана (*Allium polyrhizum*), Адамсын шарилж (*Artemisia adamsii*), алаг өвснөөс *Allium mongolicum* тааралдана. Газрын гадаргуугийн 35-65% нь хайрга чулуугаар бүрхэгдсэн энэхүү талбайд 5 зүйл ургамал бүртгэгдсэнээс ерөнхий тусгагийн бүрхэц 10-15%, ургамлын өндөр дундажаар 5-7см, 1м²-д 3-5 ширхэг зүйл ургамал тохиолдоно. Бүлгэмдлийн биомассаар ядмаг, ургац нь 0,45-1ц/га байна.

Ан амьтан: Эх газрын эрс тэс уур амьсгалтай монгол нутагт орших мөлхөгчдийн зүйлийн олон янз байдлыг дэвсгэр нутгийн хэмжээтэй харьцуулахад харьцангуй хомс ба шувуудаас Шонхортон (*Flaconiformes*), Тагтаатан (*Columbiformes*), Ураацайтан (*Adopiformes*), Боршувуутан (*Passeriformes*) зэрэг 4 багт хамаарах 20 зүйл шувуу тохиолдоно. Үүнээс гадна уурхайн талбай орчим нутгаар дамжин нүүдэлдэг, ирж зусдаг олон зүйл шувууд байх боломжтой.

Уурхайн үйл ажиллагааны цар хүрээ бага тул зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах асуудал гарахгүй бөгөөд тухайн уурхайн үйл ажиллагаанд ховор нэн ховордсон ан амьтан өртөх магадлал байхгүй байна.

2.2 Дэд бүтэц

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь дэд бүтэц сул хөгжсөн, зам харилцаа төдийлөн сайн хөгжөөгүй, аймгийн төв, сумдуудтай ердийн шороон замаар холбогдсон. Аймгийн төв болон ихэнх сумын төв эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдож, үйлвэрлэл үйлчилгээ явуулах боломжтой болсон. Дундговь аймаг нь чулуун нүүрс, хүрэн нүүрс, гөлтгөнө, алт, мөнгө, хайлуур жонш, төмрийн хүдэр, зэс, бал чулуу зэрэг ашигт малтмалын орд, илэрц элбэгтэй. Эдгээр орд, илэрцүүдийг ашиглах тохиолдолд бүс нутгийн дэд бүтэц хөгжих ирээдүйтэй.

3. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ГО БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөллийг матрицын үнэлгээний арга дээр тулгуурлан Олон улсын туршлагад өргөн хэрэглэгдэж буй нөлөөллийн үнэлгээний үр дагавар болон тохиолдох магадлалын шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан тодорхойлсон болно. Уурхайн дараах үйл ажиллагаанаас Байгаль орчинд сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Уурхайн барилга байгууламж барих
- Хөрс хуулалтын ажил
- Хүнд даацын машин механизмын хөдөлгөөн
- Уурхайн карьер үүсгэх
- Нүүрс олборлох

3.1 Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл

Нүүрс ачих, тээвэрлэх ажлын явцад болон хоосон чулуулгийн овоолгод чулуулгийг асгах түүнийг түрж тэгшлэх, ангилан ялгахад үүсэх тоос шороо нь агаарыг бохирдуулах эх үүсвэр болно.

Мөн салхи ихтэй үед их хэмжээгээр тоос шороо дэгдэх, машин механизмыг богино зайд олон эргэлттэйгээр ашигласнаар агаар дахь тоосжилт, утаа тортогийн хэмжээ CO_2 , NO_2 ихсэж, O_2 -ын хэмжээ багасна.

Уурхайн орчинд бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах онцгой асуудал байхгүй.

Уурхайн олборлолтын явцад бага хэмжээний дуу чимээ, доргио чичиргээ үүсэх магадлалтай боловч энэ нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх, онц аюултай байдал үүсэхээргүй байна. Агаарт дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон, цацраг үүсэх магадлал байхгүй.

3.2 Хөрсөнд учруулах нөлөөлөл

Нүүрс олборлох, ангилан ялгаж ачиж тээвэрлэх үйлдвэрлэлийн явцад хөрсний хими, физик шинж чанар болон ордыг геоморфологийн тогтоц, геоморфологийн үзүүлэлтэнд чанарын өөрчлөлт гарч хөрс бохирдож, эвдрэлд орно. Уурхайн орчим автомашин болон бусад тээврийн хэрэгсэл олон салаа зам гаргах, хөрс, ургамал гэмтээх, хөрсний эвдрэл үүсэх, эрчимжих зэргээс гадна нефтийн шингэн бүтээгдэхүүн хаягдаж, алдагдаснаар хөрсөнд бохирдол үүснэ. Уурхайд ажиллагсадын бохирдын цэг болон хатуу хаягдлаас байгаль орчин бохирдоно.

3.3 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөх
Үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглэсэн усыг орчинд шууд нийлүүлэхэд гадаргын усанд
бохирдол үүсэх магадлал байна. Бохирдлын гол эх үүсвэр нь ахуйн усны хэрэглээ, шатах
тослох материалын хэрэглээ болно.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Хөөт-3 нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2019 оны 10дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Аливаа төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялагийг үр ашигтай ашиглах үйл ажиллагааг зүй зохистойгоор шийдвэрлэх арга зам, түүнд шаардагдах зардлыг хамруулан тусгасан баримт бичгийг байгаль хамгаалах төлөвлөгөө гэнэ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22-р дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ төлөвлөх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан бөгөөд БОМТ нь түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баттай байлгах үндэслэл болно.

Тус төлөвлөгөөг боловсруудахдаа тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгав.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Агаарын чанар	Олборлолтын явцад карьерын ханыг ухах нураах, ачих, тээвэрлэх, овоолгонд байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсч агаарын чанарт нөлөөлөх	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг тээвэрлэлтийн үед чийгшүүлж усалгаа хийх				ҮАЗ	Үйл ажиллагааны туршид Хуурайшилтын үед	

		Нүүрс тээвэрлэх үед хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр сул шороо үүсч, тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх	Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох /40км.цагаас хэтрэхгүй байх/ тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засч сайжруулах	ш		5	ХАБЭА-н зардал тусгасан	2 дугаар улиралд	
			Уурхайн дотоод тээврийн замын сүлжээ, маршрутыг баталж мөрдөх	ш		2	ХАБЭА-н зардал тусгасан	2 дугаар улиралд	

		Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог бусад	Тээврийн хэрэгслүүд Монгол улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд				ҮАЗ	Үйл ажиллагааны туршид	
		элемент зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	АБТ төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийх				ҮАЗ	Үйл ажиллагааны туршид	
2.	Гадаргын ба газрын доорхи	Ил уурхайн гүн доошлохын хэрээр усны шүүрэлт ихсэж, уурхайгаас зайлуулах усны	Ус ашиглуулах дүгнэлт зөвшөөрөл гэрээг байгуулах, төлбөр төлөх			1	ҮАЗ	Жилийн эцэст	
	усны нөөц	хэмжээ нэмэгдэж газрын доорх ус хомсдох	Ус ашиглалт, усны зохистой хэрэглээг-сургалт мэдээлэл						

		Булгийн эхийн хог хаягдлыг цэвэрлэх хамгаалах	Нөлөөллийн бүсэд ойр орших булаг				ҮАЗ	2023	
		Уурхайн ухаш үүсэх, суваг шуудуу татах, хөрс эвдрэлд оруулах зэргээр газрын гадаргын хэлбэр дүрсийг өөрчилснөөр гадаргын урсцын байгалийн унаган тогтоц өөрчлөгдөх	Бусад шаардлагагүй тохиолдолд гадаргын хэлбэр, төрх байдлыг өөрчлөхгүй байх				ҮАЗ	Үйл ажиллагааны туршид батлагдсан УАТ-ний дагуу олборлолт хийнэ	

3.	Хөрсөн бүрхэвч	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс, ургамлан нөмрөг бохирдох	Засварын цэг, ШТМ-ын агуулах, ШТС-ийн талбайн засвар арчлалт хийх, ТТ-ийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбайд засах	мкв	250,000	20	ҮАЗ	2-3 дугаар улиралд	
		Уурхайн гал тогоо, угаалгаас гарах шингэн хаягдал, мөн хоолны үлдэгдэл, хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр хөрс бохирдох	Хог хаягдлыг асгарч гоожихгүй битүү саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаях				Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгасан	Үйл ажиллагааны туршид	

4.	Газрын хэвлий	Нүүрс олборлолтын хэмжээ нэмэгдсэн үед хөрс хуулалт хийгдэх ба тухайн талбайд хөрсөн бүрхэвч гадаргаас зайлуулагдах	Олборлолт нэмэгдэх бүрт шимт хөрсийг хуулж, стандартын дагуу хэлбэржүүлж хамгаалах				ҮАЗ	Үйл ажиллагааны туршид	
5.	Ургамлан нөмрөг	ШТМ, Машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс, ургамлан нөмрөг бохирдуулах	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах				Осол эрсдэлийн төлөвлөгөөнд тусгасан	Үйл ажиллагааны туршид	

6.		Тоосжилтын улмаас уурхайн ойр орчмын амьдрах орчин доройтох	Уурхайн тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх, салаа зам гаргахгүй байх				ҮАЗ	Үйл ажиллагааны туршид	
	Амьтны аймаг	Хог хаягдлыг /хоолны/ эмх замбараагүй хаяснаас болж зарим махчин амьтад идэх, амьтдын амьдрах орчин доройтох, бохирдох	Хог хаягдлыг ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулж байх				Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгасан	Үйл ажиллагааны туршид	
	Нийт						2,940,000		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолгын нөхөн сэргээлт	м.куб	ҮАТ			Үйл ажиллагааны туршид	ҮАТ
2.	Биологийн нөхөн сэргээлт	Уурхайн ногоон байгууламжийн арчилгаа	га	0,6	1,000,000	1,000,000	Ургамал ургалтын хугацаанд	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөний аргачлал
	Нийт					1,000,000		

7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

1. ДУА-н аймгийн БОАЖГ болон Баянжаргалан сумын ЗДТГ-аас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу техникийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ хэрэгжүүлнэ.
2. Баянжаргалан сумын Чацарганы плантацид 800ш чацарганы суулгац нийлүүлнэ.

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүрсний ордыг ашиглах уурхай орчмын олборлолт явуулах талбай болон уурхайн эдэлбэр газарт айл өрх, айл өрхийн хаваржаа намаржаа байхгүй учир нүүлгэн шилжүүлэх асуудал байхгүй боловч уурхайн үйл ажиллагаанд өртөөгүй ч нүүж шилжих айл өрх гарвал туслалцаа үзүүлэх болно.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газар олон боловч төсөл хэрэгжих бүс нутаг болон хүрээлэн буй орчинд ямар нэгэн түүхийн дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Иймд энэхүү төслийн үйл ажиллагаанаас түүх соёлын дурсгалт зүйл болон археологи болон палеонтологийн олдворт ямар нэгэн байдлаар нөлөөлөл байхгүй байна.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Гэнэтийн осол	Шаардлагатай газруудад аюулгүй байдлын тэмдэг				ХАБЭА-н зардлаас	Үйл ажиллагааны явцад	

		тэмдэглэгээ, хатуу хаалт хашилт байрлуулах, тогтмол сайжруулах						
2	Гал түймэр	Галын хор болон гал унтраах хэрэгслүүдийн ашиглах хугацаа, чанарын бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах, шаардлага хангаагүй бүрдэл хэсгийг сольж сайжруулах				ХАБЭА-н зардлаас	Улирал бүр	
3	Урьдчилан сэргийлэх	Анхны тусламжийн бүрдэл хүрэлцээтэй хэмжээгээр бэлдэх						
4	Төлөвлөгөөт сургалт	ХАБЭА-н зааварчилгаа,					Үйл ажиллагааны туршид	

		сургалтуудыг тогтмол зохион байгуулах						
5		Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэслээр бүрэн хангах		30	400,000	ХАБЭА-н зардлаас	Улирал солигдох үед	
6		Уурхайн ажилчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах				ҮАЗ	Үйл ажиллагааны туршид	
	Нийт					ХАБЭА-н зардлаас		

11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Ахуйн шингэн хаягдал цуглуулах, байгальд сөрөг нөлөөгүй нийлүүлэх	Хог хаягдлын цэг болон бохирын цооногт тогтмол ариутгал хийх	кг	10,000	10	100,000	Үйл ажилагааны туршид	Хог хаягдлын тухайн хууль, хог хаягдлыг ангилан ялгах журам
		Ахуйн хатуу хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан	Ахуйн хатуу хог хаягдлыг орон нутгийн	тн	960,000		960,000		

		ялгах, хогийн цэгүүдийг сайжруулах, шинэчлэх	нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн хүргэж устгах						
2.	Аюултай	Аюултай хог хаягдлын бүртгэл хөтлөх, техیکیйн ашигласан тос дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Тухайн бүс нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөрийг төлж барагдуулах	тн					
	Нийт						1,060,000		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

2023 оны ОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ:

1. Мониторингийн хяналтын цэгүүдийг тогтоон тэмдэгжүүлнэ.
2. Агаарын шинжилгээг СЕМ DT-96 багажаар сар бүр, хөрс болон усны шинжилгээг жилд 2 удаа батлагдсан зааварчилгааны дагуу дээж авч магадлан итгэмжлэгдсэн лабораторид илгээж шинжлүүлнэ. Ургамлын тооллого бүртгэлийг аргазүйн дагуу ургамал ургалтын хугацаанд жилд 1 удаа хийнэ.
3. Дээрх хэмжилт, тооллого, сорьцлолтыг хийхдээ тухай бүрд нь орон нутгийн иргэдээс төлөөлөл байлцуулан багажны хэмжилт, дээжний бүртгэл болон судалгааны аргазүйн дагуу бүртгэл тооллогыг үнэн бодит явуулж, баталгаажуулна.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1.	Тоосжилт PM_{10} , $PM_{2,5}$ Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд	карьер, дотоод тээврийн зам, гадаад овоолго, кемп/	Дотоод хяналт шинжилгээг сар бүр	10			Өөрийн багажаар хэмжилт хийнэ	MNS3113-1981 MNS3384:1982 MNS5061:2001 MNS0012-014:1991

2	<p>Ундны ус: стандартад заасан үзүүлэлтүүд</p> <p>Бохир ус: Умбуур бодис, рН, БХХ, ХХХ, Үлдэгдэл хлор</p>	<p>Сумаас зөөвөрлөн авдаг унд ахуйн ус, ахуйн бохир усанд шинжилгээ хийнэ.</p>	Жилд 2 удаа	3	500,000	1,000,000		<p>✓ MNS 0900 2018</p> <p>✓ MNS 6561 2015</p>
3	<p>Ялзмаг , урвалын орчин (рН), давсжилт, карбонат ($CaCO_3$), Шингээгдсэн сууриуд Ca, Mg</p>	<p>Ил уухайн овоолго, ажилчдын тосгон, засварын газар, хогийн цэг орчимд</p>	Жилд 2 удаа	1	500,000	1,000,000		<p>MNS5850:2019</p> <p>Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөөвөрдөгдөх дээд хэмжээ</p>
	<p>Механик бүрэлдэхүүн, эзэлхүүн жин Хүнд метал: Pb, Cd, Cr, Zn, Ni, Hg, As</p>			1				
	<p>Ургамлын нөмрөгийн зүйлийн тоо, арви бүрхэц, бүлгэмдэлд эзлэх хувийг гаргана. Хяналтын явцад төслийн талбайд</p>			1				

	тухайн жилийн ургамлын биомассыг харьцуулах	ургамлын бүлгэмдлийн хяналтын цэгүүд						
4	Нийт					2,000,000		

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
	1	2	3	6	7
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх чиглэлээр дотоод хяналт шалгалт зохион байгуулах	Дотоод зардал	2-3дугаар улирал	Захиргаа үйл ажиллагааны хэлтэс	
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалт зохион байгуулах	ХАБЭА-н зарда	2-3 дугаар улиралд	ХАБЭА-н инженер	

3.	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах, НБХХ, хордлого тайлах хүнс, бүтээгдэхүүнээр хангах	Гэрээний дүнгээр	Үйл ажиллагааны үед	ХАБЭА, НР хангамжийн ажилтан	
4.	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжиж ДУА-т үйл ажиллагаа явуулдаг оёдлын цехүүдээс ажилчдын өвөл зуны ээлжийн хувцсыг захиалж авах	Осол эрсдэлийн төлөвлөгөөнд тусгасан	3р сар	Уурхайн дарга, Нярав	
	Нийт	Дотоор зардал			

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	Баянжаргалан сумын 2 дугаар багийн ИНХ-д	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жилийн БОМТ-ний гүйцэтгэл /фото зургаар баталгаажуулсан/	Хагас жил, жилийн эцэст	ҮАЗ	Гүйцэтгэх захирал Уурхайн дарга БОМэргэжилтэн	Багийн ИНХ
2.	Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газар	Тайлангийн эх хувь, албан бичгийн хамт	Тухайн жилийн БОМТ-ний гүйцэтгэл /фото зургаар баталгаажуулсан/	Хагас жил, жилийн эцэст	ҮАЗ	Гүйцэтгэх захирал Уурхайн дарга БОМэргэжилтэн	Баянжаргалан сум
	Нийт				ҮАЗ		

15. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

№	Төлөвлөгөө	Төлөвлөсөн зардал
1	Сөрөг нөлөөллийн буруулах арга хэмжээ	2,940,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,000,000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	10,000,000
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБЭА-н зардал
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,060,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,000,000
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	ҮАЗ
8	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	ҮАЗ
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв		17,000,000